

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	14
3.Аудитын тайлан.....	15
3.1. Ерөнхий зүйл.....	15
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	15
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	16
3.4. Материаллаг байдал	16
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	16
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	18
3.7. Шилэн дансны мэдээлэл	19
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.9. Аудитын илрүүлэлт.....	20
Залруулсан алдаа.....	20
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	20
Аудитын зөвлөмж.....	20
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	21
3.11. Болзошгүй өр төлбөр.....	21
4. Менежментийн захидал	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	23



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ГОРХИ-ТЭРЭЛЖИЙН
БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН
ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ
ДАРГА Ц.ДУЛАМСҮРЭН ТАНАА

2021.02.25 № 07/504
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 15 ажлыг бүрэн дуусгаж 98.75 хувийн гүйцэтгэлтэй биелүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	257,608,973.87	316,956,014.87
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
312	Банканд байгаа бэлэн мөнгө	-	-
3121	Төгрөг	-	-
31211	Төрийн сангийн харилцах	-	-
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	-
33	АВЛАГА	434,539.00	250,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	434,539.00	250,000.00
34	УРЬДЧИЛГАА	54,900,000.00	-
34600	Урьдчилж гарсан зардал	54,900,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	202,274,434.87	286,706,014.87
354	Хангамжийн материал	202,274,434.87	286,706,014.87
35410	Бичиг хэргийн материал	1,376,808.66	218,773.66
35420	Аж ахуйн материал	225,460.00	351,133.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,001,600.00	-
35440	Түлш, шатах тослох материал	2,170,409.00	4,391,559.00
35450	Барилгын засварын материал	1,080,000.00	1,080,000.00
35460	Хүнсний материал	5,789,084.00	2,937,096.00
35470	Бусад хангамжийн материал	189,631,073.21	277,727,453.21
36	НӨӨЦИЙН БАРАА	-	30,000,000.00
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	-	30,000,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,086,060,176.39	1,082,015,193.79
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,086,060,176.39	1,082,015,193.79
392	Биет хөрөнгө	1,044,060,176.39	1,039,515,193.79
39201	Барилга, байгууламж, орон сууц	831,195,054.48	815,781,191.83
39202	Хуримтлагдсан элэгдэл	(37,101,268.37)	(49,993,144.32)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	262,523,138.97	173,473,373.50
39204	Хуримтлагдсан элэгдэл	(162,010,787.45)	(96,051,392.64)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	151,896,477.66	141,775,930.70
39206	Хуримтлагдсан элэгдэл	(55,698,298.92)	(49,260,844.56)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,687,232.18	67,207,367.46
39208	Хуримтлагдсан элэгдэл	(7,215,017.92)	(11,103,790.60)
39214	Бусад үндсэн хөрөнгө	68,924,736.34	89,673,426.48
39215	Хуримтлагдсан элэгдэл	(25,141,090.58)	(41,986,924.06)
393	Биет бус хөрөнгө	42,000,000.00	42,500,000.00
39301	Программ хангамж	770,000.00	500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(770,000.00)	-
39303	Бусад биет бус хөрөнгө	42,000,000.00	42,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,343,669,150.26	1,398,971,208.66
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	250,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	250,000.00
413	Өглөг	-	250,000.00
4136	Бусад өглөг	-	250,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	250,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,343,669,150.26	1,398,721,208.66
51	Засгийн газрын хувь оролцоо	1,343,669,150.26	1,398,721,208.66
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	159,944,500.00	159,944,500.00

51101	Өмч: - төрийн	159,944,500.00	159,944,500.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,139,893,205.06	1,194,945,263.46
51210	Өмнөх үеийн үр дүн	954,579,723.90	1,139,893,205.06
51220	Тайлант үеийн үр дүн	185,313,481.20	55,052,058.40
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	43,831,445.20	43,831,445.20
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,343,669,150.26	1,398,971,208.66

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	628,945,064.45	571,097,135.28
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	223,595,895.32	163,873,835.28
120	Нийтлэг татварын бус орлого	223,595,895.32	163,873,835.28
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	223,595,895.32	163,873,835.28
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	76,800,164.00	94,063,700.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	146,795,731.32	69,810,135.28
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	405,349,169.13	407,223,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	185,165,800.00	319,788,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	185,165,800.00	319,788,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	219,625,602.13	87,435,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	14,032,302.13	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	160,000,000.00	87,435,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	45,593,300.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	557,767.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	557,767.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	417,038,725.32	516,045,076.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	417,038,725.32	516,045,076.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	401,738,081.14	482,012,951.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	190,569,938.00	191,561,672.01
210101	Үндсэн цалин	190,569,938.00	142,343,977.90
210102	Нэмэгдэл	-	39,788,094.11
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	9,429,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,937,872.95	24,544,192.00
210201	Тэтгэврийн даатгал	16,277,754.15	16,633,208.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,915,027.90	1,956,849.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,532,023.72	1,707,180.00
210204	Ажилгүйдлийн даатгал	383,007.38	410,678.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,830,059.80	3,836,277.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,984,491.00	23,147,243.00
210301	Гэрэл, цахилгаан	22,233,514.00	20,827,243.00
210302	Түлш, халаалт	1,715,477.00	-
210303	Цэвэр, бохир ус	1,035,500.00	2,320,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,714,722.84	34,882,917.00
210401	Бичиг хэрэг	2,181,007.84	2,101,055.00
210402	Тээвэр, шатахуун	13,914,500.00	30,010,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,411,431.00	2,076,687.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	720,737.00	695,175.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	487,047.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	755,600.00	303,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	148,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	155,000.00
210604	Урсгал засвар	755,600.00	-
2107	Томилолт, зочны зардал	9,928,829.00	3,077,400.00
210702	Дотоод албан томилолт	9,928,829.00	3,077,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,558,943.00	77,624,298.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,189,443.00	76,004,798.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	320,000.00	320,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	49,500.00	49,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	126,287,684.35	126,872,229.88
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,140,956.56	7,141,088.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,940,000.00	1,941,624.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	120,206,727.79	117,789,517.88
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,300,644.18	34,032,124.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,957,767.00	-
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	557,767.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,400,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,342,877.18	34,032,124.99
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,342,877.18	34,032,124.99
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	211,906,339.13	55,052,058.40
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	26,592,857.95	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	26,592,857.95	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(26,592,857.95)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	185,313,481.18	55,052,058.40

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	482,149,333.1	501,580,520.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	76,800,164.0	94,357,220.0
120	Нийтлэг татварын бус орлого	76,800,164.0	94,357,220.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	76,800,164.0	94,357,220.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	76,800,164.0	94,357,220.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	405,349,169.1	407,223,300.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	185,165,800.0	319,788,300.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	185,165,800.0	319,788,300.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	219,625,602.1	87,435,000.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	14,032,302.1	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	160,000,000.0	87,435,000.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	45,593,300.0	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	557,767.0	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	557,767.0	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	482,149,333.1	501,580,520.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	482,149,333.1	501,580,520.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	466,848,689.0	467,298,395.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	175,767,382.9	191,561,672.0
210101	Үндсэн цалин	135,653,882.9	142,343,977.9
210102	Нэмэгдэл	30,683,900.0	39,788,094.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,429,600.0	9,429,600.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,756,576.1	24,544,192.0
210201	Тэтгэврийн даатгал	16,175,776.1	16,823,392.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,645,200.0	1,930,100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,316,200.0	1,544,100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	329,000.0	386,100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	3,290,400.0	3,860,500.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,083,600.0	23,147,243.0
210301	Гэрэл, цахилгаан	16,957,600.0	11,183,100.0
210302	Түлш, халаалт	7,090,500.0	9,644,143.0
210303	Цэвэр, бохир ус	1,035,500.0	2,320,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	7,240,867.0	32,854,059.0
210401	Бичиг хэрэг	1,030,767.0	763,459.0
210402	Тээвэр, шатахуун	3,712,200.0	28,400,900.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,388,800.0	1,980,600.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	109,100.0	1,709,100.0
2105	Нормативт зардал	7,414,500.0	346,500.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,414,500.0	346,500.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,326,100.0	148,000.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,751,100.0	148,000.0
210604	Урсгал засвар	2,575,000.0	-
2107	Томилолт, зочны зардал	9,928,829.0	3,077,400.0
210702	Дотоод албан томилолт	9,928,829.0	3,077,400.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	207,217,334.0	189,424,329.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	205,847,834.0	187,804,829.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.0	1,000,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	320,000.0	320,000.0

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	49,500.0	49,500.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.0	250,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,113,500.0	2,195,000.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,113,500.0	2,195,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,300,644.2	34,282,125.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,957,767.0	-
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	557,767.0	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,400,000.0	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,342,877.2	34,282,125.0
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,342,877.2	34,282,125.0
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	-
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	159,944,500.00	43,831,445.20	954,579,723.88	1,158,355,669.08
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	159,944,500.00	43,831,445.20	954,579,723.88	1,158,355,669.08
4	Тайлант үеийн үр дүн	-	-	185,313,481.18	185,313,481.18
5	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	159,944,500.00	43,831,445.20	1,139,893,205.06	1,343,669,150.26
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	159,944,500.00	43,831,445.20	1,139,893,205.06	1,343,669,150.26
8	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
9	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
10	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
11	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
12	Тайлант үеийн үр дүн	-	-	55,052,058.40	55,052,058.40
13	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	159,944,500.00	43,831,445.20	1,194,945,263.46	1,398,721,208.66

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	389,288,300.00	380,116,395.01	9,171,904.99	97.6
УРСГАЛ ЗАРДАЛ	389,288,300.00	380,116,395.01	9,171,904.99	97.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	389,288,300.00	380,116,395.01	9,171,904.99	97.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	193,019,500.00	191,561,672.01	1,457,827.99	99.2
Үндсэн цалин	143,797,000.00	142,343,977.90	1,453,022.10	99.0
Нэмэгдэл	39,792,900.00	39,788,094.11	4,805.89	100.0
Унаа хоолны хөнгөлөлт	9,429,600.00	9,429,600.00	-	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,120,800.00	24,544,192.00	1,576,608.00	94.0
Тэтгэврийн даатгал	18,400,000.00	16,823,392.00	1,576,608.00	91.4
Тэтгэмжийн даатгал	1,930,100.00	1,930,100.00	-	100.0
ҮОМШӨ-ний даатгал	1,544,100.00	1,544,100.00	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	386,100.00	386,100.00	-	100.0
Эрүүл мэндийн даатгал	3,860,500.00	3,860,500.00	-	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,193,600.00	23,147,243.00	46,357.00	99.8
Гэрэл, цахилгаан	11,183,100.00	11,183,100.00	-	100.0
Түлш, халаалт	9,645,000.00	9,644,143.00	857.00	100.0
Цэвэр, бохир ус	2,365,500.00	2,320,000.00	45,500.00	98.1
Хангамж, бараа материалын зардал	32,854,500.00	32,854,059.00	441.00	100.0
Бичиг хэрэг	763,900.00	763,459.00	441.00	99.9
Тээвэр, шатахуун	28,400,900.00	28,400,900.00	-	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,980,600.00	1,980,600.00	-	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,709,100.00	1,709,100.00	-	100.0
Нормативт зардал	346,500.00	346,500.00	-	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	346,500.00	346,500.00	-	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	148,100.00	148,000.00	100.00	99.9
Багаж, техник, хэрэгсэл	148,100.00	148,000.00	100.00	99.9
Томилолт, зочны зардал	3,077,400.00	3,077,400.00	-	100.0
Дотоод албан томилолт	3,077,400.00	3,077,400.00	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	108,332,900.00	102,242,329.00	6,090,571.00	94.4
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	106,713,400.00	100,622,829.00	6,090,571.00	94.3
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	320,000.00	320,000.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн оношилгоо	49,500.00	49,500.00	-	100.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	250,000.00	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	2,195,000.00	2,195,000.00	-	100.0

Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,195,000.00	2,195,000.00	-	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	389,288,300.00	380,116,395.01	9,171,904.99	97.6
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	319,788,300.00	285,759,175.01	34,029,124.99	89.4
Улсын төсвөөс санхүүжих	319,788,300.00	285,759,175.01	34,029,124.99	89.4
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	69,500,000.00	94,357,220.00	(24,857,220.00)	135.8
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	69,500,000.00	94,357,220.00	(24,857,220.00)	135.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
АЖИЛЛАГСДЫН ТОО	18.00	18.00	-	100.0
Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	13.00	13.00	-	100.0
Үйлчлэх ажилтан	4.00	4.00	-	100.0
СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	-	-	-	-
ЭМЧЛҮҮЛЭГСДИЙН ТОО	-	-	-	-

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		87,182,000.00
УРСГАЛ ЗАРДАЛ		87,182,000.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		87,182,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		87,182,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		87,182,000.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		87,182,000.00
Нэмэлт санхүүжилтийн орлого		87,182,000.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		87,182,000.00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Ц.Дуламсүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл, тайлагнал болон дотоод хяналтын системийг сайжруулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Мүүрь Аудит ХХК-ийн ахлах менежер Н.Дагийрагчаа, аудитын туслах М.Гантуяа болон Х.Өсөх-Эрдэнэ нар хариуцаж хэрэгжүүлэв.

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 сарын 22-ны өдрийн 21/26 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Байгалийн өвөрмөц тогтоц, экосистемийн онцлог төрх, байгалийн үзэгдэл, үйл явц болон нийслэл хотын ундны цэвэр усны нөөцийг хамгаалах, бүх нийтийн экологийн мэдлэгийг дээшлүүлж, байгалийн баялгийг зүй зохистой, тогтвортой ашиглах, аялал жуулчлалыг хөгжүүлэх үйл ажиллагааг зохицуулахад оршино”.

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны гол үйл ажиллагаа нь Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газар, Нагалхааны байгалийн нөөц газрын хилийн зааг болон хил доторхи газар нутгийн байгалийн унаган төрхийг хадгалан хамгаалах, шинжлэн судлах, зүй зохистой ашиглахтай холбогдсон арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд орсон өөрчлөлтүүдийг тус тус дагаж мөрдөж ажилласан байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр **нийт зардлыг** сонгож, эрсдэлийн түвшинг “**дунд**” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг **1** хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны 2 дугаар улирлын тайлангийн нийт зардлын 214,129.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,141.2 мянган төгрөгөөр тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 5,160.4 мянган төгрөгөөр тооцсон нь 2020 оны жилийн эцсээр нийт зардлын дүн өссөнтэй холбоотой болно.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 55,302.1 мянган төгрөгөөр буюу 4.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урьдчилж гарсан зардал, бараа материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	
Авлага	434.5	250.0	-184.5
Урьдчилгаа	54,900.0	-	-54,900.0
Бараа материал	202,274.4	286,706.0	84,431.6
Үндсэн хөрөнгө	1,086,060.2	1,082,015.2	-4,045
Бусад эргэлтийн хөрөнгө	-	30,000.0	30,000
Нийт хөрөнгө	1,343,669.1	1,398,971.2	55,302.1
Өр төлбөр	-	250.0	250.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,343,669.1	1,398,721.2	55,052.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,343,669.1	1,398,971.2	55,302.1

Тайлант онд 293.5 мянган төгрөгийн ажиллагсадтай холбоотой авлагыг байгууллагын дансанд төвлөрүүлж, 141.0 мянган төгрөгийн татварын авлагыг татварын өглөгт тохируулан бүртгэснээр нийт 434.5 мянган төгрөгийн авлага бүрэн төлөгдөж дууссан.

Авлага дансны үлдэгдэл 250.0 мянган төгрөг нь 2020 онд үүссэн Сангийн яамнаас авах татаас санхүүжилтийн авлага болно.

Бараа материалын дансны үлдэгдэл 286,706.0 мянган төгрөг болж 84,431.6 мянган төгрөгөөр өссөн нь:

- Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2020 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн А/31 болон А/32 тоот тушаал мөн 2020 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн А/421 тоот тушаалаар санхүүжүүлсэн хөрөнгөөр 54,962.0 мянган төгрөгийн материал,
- Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/159 дугаар тушаал мөн Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газарт булаг шанд тохижуулах төслийн хүрээнд Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал болон Ургамал хамгааллын зардлын батлагдсан төсвөөс 33,485.8 мянган төгрөгийн материал авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,082,015.2 мянган төгрөг болж 4,045.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд дараах үндсэн хөрөнгүүдийг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн .Үүнд:

- 2020 оны 02 дугаар сарын 04-ний Байгаль орчин, аялал жуулчлалын яамны төрийн нарийн бичгийн А/32 тоот тушаалаар 19,034.4 мянган төгрөгийн 28 ширхэг ойн хөдөлгөөн мэдрэгч камер,
- Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2020 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/257 дугаар “Жагсаалт батлах тухай” тушаалын дагуу “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох” төслийн хүрээнд 52,020.1 мянган төгрөгийн 127 ширхэг бүхий тавилга, тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авсан.
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 687 дугаар бүхий “Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай” тогтоолоор 17,790.0 мянган төгрөгийн 43 ширхэг компьютер, тоног төхөөрөмжийг орлогоор зөвшөөрч бүртгэсэн.
- Мөн 2019 оны урьдчилж гарсан зардлын данстай холбоотойгоор 3,000.0 мянган төгрөгийн гар бөмбөгийн хэрэгсэл, 3,300.0 мянган төгрөгийн зогсоол, 3,000.0 мянган төгрөгийн сагсан бөмбөгийн шийд, 9,100.0 мянган төгрөгийн талбай болон 6,500.0 мянган төгрөгийн био ариун цэврийн зөөврийн өрөө гэх мэт нийт 24,900.0 мянган төгрөгийн хөрөнгийг орлогоор бүртгэн авснаар нийт 113,744.5 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.

Тайлант онд дараах үндсэн хөрөнгүүдийг данснаас хасаж акталсан байна. Үүнд:

- Үндсэн хөрөнгө нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 10 дугаар сарын 08-ны 497 дугаар “Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай” тогтоолоор мотоцикл, явган зам, усан оргилуур, мод гэх мэт 33,720.0 мянган төгрөгийн 28 ширхэг хөрөнгө,
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А-1/1687 дугаар “Зөвшөөрөл олгох тухай” тогтоолоор 17,919.2 мянган төгрөгийн GPS, дуран, машины станц гэх мэт 20 ширхэг тоног төхөөрөмж,
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 687 дугаар бүхий “Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай” тогтоолоор 35,417.5 мянган төгрөгийн 43 ширхэг компьютер, тоног төхөөрөмж
- Мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 627 дугаар “Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай” тогтоолоор 70,273.0 мянган төгрөгийн Ланд-105 болон портер машинуудыг худалдан борлуулснаар нийт 157,329.8 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хасаж бүртгэсэн байна.

Биет бус хөрөнгө нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 687 дугаар бүхий “Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай” тогтоолоор 270.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлд 250.0 мянган төгрөгийн Баянхадат тур ХХК-д өгөх өглөг байна.

Энэхүү 250.0 мянган төгрөгийн өр нь 2020 оны 02 дугаар сарын 04-ний Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын А/32 дугаар тушаалын дагуу хийгдсэн хурал семинар зохион байгуулах ажлын үлдэгдэл төлбөр болно.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,398,721.2 мянган төгрөг болж 55,052.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 57,847.9 мянган төгрөгөөр буюу 9 хувиар буурсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 94,063.7 мянган төгрөг болж өмнөх оны үзүүлэлтээс 22.5 хувиар өссөн. Энэ нь тайлант онд хуш модны самар бэлтгэж ашиглахыг зөвшөөрсөнтэй холбоотой байна. Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 69,810.1 мянган төгрөг болж 52 хувиар, нэмэлт санхүүжилтийн орлого 87,435.0 мянган төгрөг болж 60 хувиар тус бүр буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 99,006.3 мянган төгрөгөөр буюу 23.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж болон тээвэр шатахууны зардлууд байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 377,579.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 11,708.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 389,288.3 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн төсөл болон өмнөх оны баталсан төсвөөс 133,622.5 мянган төгрөг буюу 50 хувиар өссөн өөрчлөлттэй байна.

Энэ нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн харьяа төсвийн байгууллагын дарга, төсвийн захирагч нарт хүргүүлсэн “2020 оны төсвийн тухай” албан бичиг мөн Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2020 оны 03 дугаар сарын 12-ны 10/1624 дугаартай тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаадад хүргүүлсэн “Нэмэлт төсвийн талаар чиглэл хүргүүлэх тухай” албан бичгүүдтэй холбоотойгоор цалин хөлс, тээвэр шатахуун болон бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн төсвийн төсөл болон батлагдсан төсөв нэмэгдсэнтэй холбоотой байна.

Дээд шатны төсвийн захирагч тайлант оны эхэнд 348,139.2 мянган төгрөгийг улсын төсвөөс 70,500.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр нийт

418,639.2 мянган төгрөгийн төсөв баталсан боловч 2020 оны 11 дүгээр сарын 02-нд нэмэлт тодотгол хийн улсын төсвөөс 318,163.8 мянган төгрөгийг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 69,500.0 мянган төгрөгийг нийт 387,663.8 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр баталж өөрчлөлт оруулсан байна. 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдөр 1,624.5 мянган төгрөгийн санхүүжилтийг байгууллагад олгосноор 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр баталсан төсөв дээр нэмэгдэж нийт 389,288.3 мянган төгрөг болсон.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр 389,288.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 319,788.3 мянган төгрөгийг улсын төсвөөс 69,500.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс урсгал үйл ажиллагааны санхүүжилт болон нэмэлт санхүүжилтийн орлогоор нийт 407,223.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 94,063.7 мянган төгрөг, 2019 оны төлөгдсөн авлагатай холбоотой 293.5 мянган төгрөгийн бусад орлого, нийт 501,580.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 467,298.3 мянган төгрөгийг зарцуулж 34,282.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 380,116.3 мянган төгрөг буюу 97.7 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил болон ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 3,034.4 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 6,090.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 87,435.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс үндсэн хөрөнгө худалдан авахад 19,034.4 мянган төгрөг, бараа материал худалдан авахад 57,790.3 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнд 10,357.3 мянган төгрөг нийт 87,182.0 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 253.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 140 мэдээлэл, хугацаа хоцроосон 9 мэдээлэл, 5,500.0 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлоготой холбоотой 1 мэдээлэл, 5,376.7 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны зардалтай холбоотой 1 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлсэн байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 60,179.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 43,141.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 10,876.7 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 6,161.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө. Мөн дотоод хяналтын зөрчилд албан шаардлага, зөвлөмжийн хамт өгсөн.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 13,141.4 мянгаар дутуу тооцож бүртгэснийг залруулав.
2. 30,000.0 мянган төгрөгийн өртөгтэй “Мэдээллийн төвийн байр”-ыг /90-95 хувийн гүйцэтгэлтэй/ урьдчилж гарсан зардал дансанд бүртгэсэн байсныг бусад эргэлтийн хөрөнгө дансанд залруулан бүртгэсэн.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 10,876.7 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчилд 1 албан шаардлага, дүн тодорхойлох боломжгүй дотоод хяналтын алдаанд 1 албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

1. Шилэн дансанд 10,876.7 мянган төгрөгийн мэдээлэл байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3. “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”; 4.1.4. “хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх” гэсэн заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага өгсөн.

2. 2020 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн Байгаль Орчин, Аялал Жуулчлалын сайдын “Ойгоос хуш модны самар бэлтгэж ашиглахыг бүсчлэн тогтоох тухай” А/577 тоот тушаалын дагуу тус байгууллагад ойн дагалт нөөц ашиглах 1000 /нэг мянга/ ширхэг эрхийн бичгийг олгосон. Дээрх эрхийн бичгийн тооцоог тулган шалгахад 5448 болон 400 дугаар бүхий 2 ширхэг дутсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6. “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага өгсөн.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 6,161.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн ангилалтай холбоотой зөрчилд 1 зөвлөмж, дотоод хяналттай холбоотой алдаанд 1 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс санхүүгийн тайлангийн дүгнэлт гарах хүртэл хугацаанд материаллаг нөлөө бүхий үйл явдал байхгүй байна.

3.11. Болзошгүй өр төлбөр

2020 оны 10 дугаар сарын 07-ны өдөр Монгол дахь Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй /GIZ / 2018 онд хамтран ажиллаж байсан мэргэжилтний үлдэгдэл цалин гэх 528.8 мянган төгрөгийн өр төлбөр нэхэмжилсэн байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Дотоод хяналттай холбоотой асуудал-1

1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийг тооллогын баримттай тулган шалгахад гар бөмбөг, бэлтгэлийн хувцас хэрэгсэл, самбар гэх мэт УСНББОУС-17 Үндсэн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлтийн шаардлагыг хангаагүй 6,161.1 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг үндсэн хөрөнгө дансанд бүртгэсэн байна.

1.2. Эрсдэл:

Үндсэн хөрөнгийн дүн болон элэгдлийн зардал илүү илэрхийлэгдэж, санхүү үр дүнгийн тайланд нөлөөлөх

1.3. Өгсөн зөвлөмж:

УСНББОУС-17 шалгуурт нийцсэн хөрөнгийг үндсэн хөрөнгөөр бүртгэх нь зүйтэй. Цаашид үндсэн хөрөнгийн ангиллыг дахин хянаж, стандарт болон бодлогын баримт бичигт нийцэхгүй зүйлсийг тодруулж, үндсэн хөрөнгөөс хасаж, бараа материалд шилжүүлэх талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүсэлт өгч шийдвэрлүүлэх, бодлогын баримт бичгийг тууштай мөрдөн ажиллах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлээр үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтан нар танилцаж хүлээн зөвшөөрсөн болно.

2. Дотоод хяналттай холбоотой асуудал-2

2.1. Илрүүлэлт:

- 2020 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн Байгаль Орчин, Аялал жуулчлалын сайдын “Ойгоос хуш модны самар бэлтгэж ашиглахыг бүсчлэн тогтоох тухай” А/577 тоот тушаалын дагуу тус байгууллагад ойн дагалт нөөц ашиглах 1000 /нэг мянга/ ширхэг эрхийн бичгийг олгосон. Дээрх эрхийн бичгийн тооцоог тулган шалгахад 5448 болон 400 дугаар бүхий 2 ширхэг дутсан.
- Мөн Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт бүс рүү нэвтрэх хураамж болох 300 болон 3000 төгрөгийн үнэ бүхий тасалбар тасалж бэлэн мөнгөөр орлого хураадаг. Энэхүү хураамжийн бэлэн мөнгөн орлогыг цаг тухай бүрд нь байгууллагын харилцах дансанд тушаагаагүй олон хоногоор хуримтлуулж тушаасан байна. Мөн эдгээр үнэт цаасны тооцоог цаг тухай бүрд тулган шалгаж үлдэгдлийг тоолж баталгаажуулаагүй байна.

2.2. Эрсдэл:

Бэлэн мөнгөний орлогыг цаг тухай бүрд нь харилцах дансанд тушаадаггүй, дотоод хяналтгүйн улмаас залилангийн эрсдэл үүсэх, үндсэн үйл ажиллагааны орлого дутуу илэрхийлэгдэж санхүүгийн үр дүнд нөлөөлөх

2.3. Өгсөн зөвлөмж:

- Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын дагуу ойн дагалт нөөц ашиглах эрхийн бичиг болон нэвтрэх хураамжийн орлогыг цаг тухай бүрд нь харилцах дансанд тушааж хэвших нь зүйтэй.
- Тодорхой хугацаагаар тасалбар болгон үлдэгдлийг тоолж баталгаажуулж хяналт тавьж ажиллах

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлээр үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтан нар танилцаж хүлээн зөвшөөрсөн болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021.02.10			САГ-2021/38/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Горхи-Тэрэлжийн БЦГ-ын хамгаалалтын захиргаа		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Шилэн дансанд мэдээлэл дутуу байршуулсан.	10,876.7	Албан шаардлага	Дарга Нягтлан бодогч	Ц.Дуламсүрэн Б.Гандолгор
2	Ойн дагалт нөөц ашиглах эрхийн бичиг тооллогоор дутсан.	-	Албан шаардлага	Дарга Нягтлан бодогч	Ц.Дуламсүрэн Б.Гандолгор
3	Орлоготой холбоотой анхан шатны баримт бүрдүүлэлт болон дотоод хяналт хангалтгүй.	-	Зөвлөмж	Дарга Нягтлан бодогч	Ц.Дуламсүрэн Б.Гандолгор
4	Үнэ болон ашиглах хугацаа бага хөрөнгийг үндсэн хөрөнгөөр бүртгэсэн.	6,161.1	Зөвлөмж	Дарга Нягтлан бодогч	Ц.Дуламсүрэн Б.Гандолгор
ДҮН		17,037.8			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 56/АО/70078

Улаанбаатар хот

С.ДТ- 2021/38/СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа нь нийт 1000 /нэг мянга/ ширхэг ойн дагалт нөөц ашиглах эрхийн бичиг авснаас 5448 болон 400 дугаартай эрхийн бичгүүд тооллогоор дутсан, мөн байгууллагын шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаа хоцроосон 9 мэдээлэл, 10,876.7 мянган төгрөгийн мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй байна.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 4.1.4-т “хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн

ШААРДАХ нь:

1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж мэдээллийг үнэн зөв, ил тод, хугацаанд нь байршуулах, тооллогоор дутагдсан эрхийн бичгүүдийг дахин нягталж шалган, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дарга Ц.Дуламсүрэн, нягтлан бодогч Б.Гандолгор нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

МҮҮРЬ АУДИТ ХХК-ИЙН МЭРГЭЖЛИЙН
ҮЙЛЧИЛГЭЭ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ЦЭРЭНХҮҮ

У.ОЮУНАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тосгуур-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

0010126398

\\10.10.10.200\Bichig_Kherig\Yawsan_Bichig\2021\0225auditin 2-R Gazar32.Docx

001081125

[illegible]

[illegible]

[illegible]